
БАЯН ТАЛ
ГОВЬСҮМБЭР
МЭДЭЭЛЭЛ
2024.10.07

## Сумын удирдах ажилтны шуурхай хуралдаан

- Хэлэлцэж буй асуудал:
- 1. “Яг цагтаа” аян зохион байгуулах тухай сумын Засаг даргын захирамж танилцуулах, үүрэг чиглэл өгөх.
- 2.Өвөлжилтийн бэлтгэл ажлын талаар бүх байгууллагуудын төлөвлөгөө, биелэлт хяналт
- 3. Хөдөөгийн багуудаар амралтын өдрүүдэд бүх байгууллагын дарга, холбогдох мэргэжилтэн оролцсон баг бүрэлдэхүүн явж ажиллах.
- 4. “Цэмцгэр Баянталчууд” аяны хүрээнд нийтийн их цэвэрлэгээний талаар
- 5.Ахмадын баяр, багш нарын баярыг сумын хэмжээнд сайтар зохион байгуулах





- 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит 20 дугаар хуралдаанаар 5 асуудал хэлэлцэхээс 1 асуудал татуулж, 4 асуудлыг шийдвэрлэж батлуулсан.



# Санхүү төсөв:9 дүгээр сарын орлогын бүрдүүлэлтийн талаар /өссөн дүнгээр/

2024 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар 149,945.0 мянган төгрөг төлөвлөгөө батлагдсанаас гүйцэтгэлээр 301,319.5 мянган төгрөг буюу 200.9 хувиар орлогыг давуулан биелүүлсэн байна.

Баянтал сумын нэгтгэлийн /ОН/ өглөг 2,893.6 мянган төгрөг , авлага 4,341.9 мянган төгрөг байна.

**2024 оны 09 дүгээр сарын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл**



# Санхүү төсөв: 2024 оны сумын төсвийн талаар

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 дүгээр сарын 25 ны өдрийн 06 дугээр тогтоолоор Сумын 2024 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулан 2,936,343.4 мянган төгрөгөөр батлагдсан байна. Үүнээс ОНХС-п 14,260. мянган төгрөгийг нэмэгдүүлэн баталж, сумын өвс тэжээлийн нөөц бүрдүүлэхэд зарцуулахаар баталсан байна. Сумын орлого нутгийн орлогыг Суутгагчийн ХХ-д олгох ОАТатварыг 40,000.0 мянган төгрөгөөр, Цалин хөлс түүнтэй адилтгах ОАТатварыг 20,000.0 мянган төгрөг нийт 60,000.0 мянган төгрөгөөр орлогыг нэмгдүүлэн баталж, ЗДНХ-20,000.0 мянган төгрөг, аймгийн төсвөөс авах дэмжлэгээс 40,000 мянган төгрөгийг бууруулан зарцуулахаар батлуулсан байна.





# Байгаль орчны чиглэлээр хийсэн ажил

Баянтал сумын зүүн урд байрлах төв хогийн цэг, хуучин наадмын талбай, хуучин цэцэрлэгийн барилгын туурь хог хаягдалыг ачиж, зөөвөрлөх, тээвэрлэж, булшилсан бөгөөд төв хогийн цэгийг цэвэрлэхэд HOVO сонсмол, Ковш зэрэг техник хэрэгсэл ашиглан хур хог хаягдлын зардлаас 1,560.0 мянган төгрөгийн түлш зарцуулан 3 га газрын хогийг цэвэрлэж, зөөвөрлөж, тээвэрлэх ажлийг хийж гүйцэтгэсэн байна. Төв хогийн цэг дээр сард дундаар 94.4 тн хог хаягдал хаядаг бөгөөд жилд 1132.8 тн хог хаягдлыг төв хогийн цэг дээр хаядаг байна.

**Анх төв хогийн цэг**









**Цэвэрлэсний дараа**









- **Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны хүрээнд:**

**1.** Сумын төсөвт тодотгол орсонтой холбогдуулан Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг ИТХ-р оруулан шинэчлэн баталсан.



2. 2024 оны 09-р сар хүртэлх ОНХС-гийн үйл ажиллагаанд 2024 оны 09-р сарын 30-ны өдөр Хяналт үнэлгээ шинжилгээний хэлтэс нь хяналт шалгалт хийж, заавар зөвлөгөө өгч ажилласан






**Нийгмийн бодлогын хүрээнд:**

1. Хүүхэд хамгаалал, хамтарсан багт 2019-2023 оны үйл ажиллагаанд Төрийн аудит орсон





- 2024 оны 10 дугаар сарын 04-ний өдөр 10 га газарт намрын мод тарилтыг нэг мод 3500 буюу 3,5 сая төгрөгөөр 1000 модыг 6 байгууллагын 70 гаран хүн оролцож тарисан.







- Статистикийн мэргэжилтэн, 2 багийн дарга нар МАЛЫН АШИГ ШИМИЙН судалгааны ажлаар хөдөө ажиллаж байна.







- Зүүн, баруун гэр хорооллын гудамжны гэрэлтүүлэг, цамхаган гэрэлтүүлгүүдийн цагийн хуваарьт өөрчлөлт оруулж тохиргоог хийн бүрэн асаалаа.








БАТЛАВ

ЗАСАГ ДАРГА З.БАТТУЛГА

2024 оны 9 сарын 24 өдөр

"АХМАДЫН БАЯР"-ЫГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ, ХӨТӨЛБӨР

2024.09.24

НҮБ-ын Ерөнхий ассамблей 1992 оноос эхлэж, жил бүрийн 10 дугаар сарын 1-ний өдрийг Олон Улсын Ахмадын баяр болгон тэмдэглэхийг дэлхий даяар албан ёсоор тунхагласны дагуу манай улс 1992 оноос эхлэн ахмадын баярыг тэмдэглэсээр 32 дахь жилтэйгээ золгож байна.

Зорилго: Сумын ахмадын баярыг тэмдэглэн өнгөрүүлж, хүндэтгэл үзүүлэх, ахмад настнуудын өмнө тулгамдаж байгаа асуудлаар санал бодлыг солилцох, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд оршино.

Хамрах хүрээ: 55-аас дээш насны эмэгтэй

60-аас дээш насны эрэгтэй

Зохион байгуулагдах арга хэмжээ

- $10^{00}$ цагт Соёлын төвд бүртгэл
- $10^{30}$ цагт Баярын хурал
- $11^{00}$ цагт Сургалт
- $11^{30}$ цагт Тэмцээн / АХА, хөгжөөнт тэмцээн, даарлас, гранд голд/
- $14^{00}$ цагт Өдрийн хоол
- $15^{00}$ цагт Ахмадуудад албан байгууллага, аж ахуй нэгж, иргэдээс хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ
- $16^{00}$ цагт завсарлага
- $19^{00}$ цагт Соёл урлагийн арга хэмжээ

Хэзээ: 2024 оны 10-р сарын 01-ний өдөр

Хаана: Сумын Соёлын төвд

Зохион байгуулагч: Засаг даргын Тамгын газар
Сумын Ахмадын хороо
Соёлын төв

Төлөвлөгөөг хянасан
Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Шинэбаяр

Удирдамж, хөтөлбөр боловсруулсан:
НБХМэргэжилтэн М.Бодьгэрэл

- Байгууллагууд харьяалалтай ахмадууддаа хүндэтгэл үзүүлж ажиллаа.
- Орон нутагтаа олон жил үр бүтээлтэй ажилласан ахмадууддаа "Говьсүмбэрийн төлөө" медаль, аймаг, сумын 30 жилийн ойн хүндэт тэмдэгийг гардууллаа.
- Сумын ахмадын баяр тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээг 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулж нийт 80 ахмад хамрагдсан. Тус арга хэмжээгээр 6 төрлийн тэмцээн уралдааныг зохион байгуулсан.

# Ахмадын баяр







# ЕБСургуулийн мэдээлэл

- 09 дугаар сарын 02- 20 хооронд сургуулийн удирдлагын баг болох захирал, сургалтын менежер, 2 заах аргын нэгдлийн ахлагч хоол зүйч, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан нар багш ажилтан, суралцагч, эцэг эхээс авсан саналыг нэгтгэн 2024-2025 оны хичээлийн жилийн төлөвлөлт, менежментийн зураглалыг хийсэн.
- 09 дугаар сарын 20нд ЕБС- удирдлагын баг “ЕБС-ийн менежментийг дэмжих арга зүйн зөвлөмж” сэдэвт сургалтад хамрагдсан.
- 09 дугаар сарын 23,24 өдрүүдэд “Алтан намар” спортын бага наадмыг бага дунд ангийн сурагчдын дунд зохион байгуулсан.
- 09 дугаар сарын 28-29 нд Монголын багш нарын баяыг угтан зохион байгуулагдсан спортын арга хэмжээнд сургуулийн багш ажилчид гар бөмбөг,шатар, теннис, сагсан бөмбөгийн төрөлд амжилттай оролцсон.

# ЭМТ-н Мэдээ мэдээлэл

- Амбулаторын үзлэг- 300
- Яаралтай тусламж- 65
- Идэвхитэй хяналт-2
- Өдрийн эмчилгээ- 10
- Хэвтэн эмчлүүлсэн- 9
- Гэрийн эргэлт - 0
- Нярайн эргэлт- 2
- Товлолт дархлаажуулалт -9
- Алсын дуудлага Том хүн- 0 хүүхэд-0
- Ойрын дуудлага-Том хүн- 26 хүүхэд- 2
- Зам тээврийн осол- 0
- Сахарын шинжилгээ - 13
- Тэмбүү-21
- Дох-20
- Ц Верус-21
- Б. Верус-21

## ЭМТ-ын  Дотоод үйл ажиллагаа

Эрүүл мэндийн төв нь 2 давхарын өрөө, тасалгаанууд урсгал засвар хийж үйлчлүүлэгчдийн тав тухтай орчинг бүрдүүлэн ажиллаж байна.

Өмнө нь



Одоо



# ЭМТ-н Нийтийн үйл ажиллагаа

- Сумын 30 –н жилийн ойгоор сумын төвд байралдаг  хуучин онгоцны хөшөөг 4,5 сая төгрөгний санхжүүлтээр засварын ажил хийж ЗДТГ-т хүлээлгэн өгсөн.















# ЭМТөв

Тэр бум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд намрын мод тарилтын ажилд өөрийн хуваарьт газарт  Эрүүл мэндийн төвийн ажилчид мод  тарьж усалгаа хийлээ.








# Цэцэрлэг

2024 оны 09-р сарын 25-ны өдөр ахмад багш Ё.Нансалмаа, Г.Нямхүү нарыг урин зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулж “Интерактивд суурилсан багшлахуй ба суралцахуй” сэдвээр санал солилцон ахмад багш нараасаа туршлага судалсан.





Хүүхдийн өдрийн дэглэмийн дагуу, хүүхдийн эрүүл мэнд, дадал хэвшлийн цагаар хүүхдүүдийн гарыг тогтмол угаалгах, шүдийг хоол идсэний дараа угаалгаж, хүүхдийг аливаа халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Мөн эрүүлжүүлэх чийрэгжүүлэх ажлаар хүүхдийг унтаад сэрсний дараа, алжаал тайлах цэгэн массажны алхалт хийлгэж, цэвэр агаар үйл ажиллагааг зохион байгуулан бүлгийн 65 хүүхдийг цэвэр агаарт гаргаж, дасгал хөдөлгөөн, алхалт хийлгэж байна.







- Баянтал сумын засаг даргын тамгын газраас, тус цэцэрлэгийн Нүүдлийн бүлэг буюу зуны гэр цэцэрлэгийн хүүхэд багачуудад зориулж шинэ гэрийг хүлээлгэн өглөө.







## Баянтал сумын цагдаагийн хэсэг

- Баянтал сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд 128 цагийн эргүүлийн үүрэг гүйцэтгэж иргэд, байгууллагаас 5 дуудлага мэдээлэл ирсэн сонгуультой холбоотой 2 дуудлага, 6 гомдол мэдээлэл 1 хэрэг шийдсэн.
- Сонгуулийн хэсгийн хороодыг камерын системээр хянах холболт хийсэн.
- "Ногоон бүс" арга хэмжээний хүрээнд 5 камер олон нийтийн газар байршуулсан
- Шугам замд үүрэг гүйцэтгэсэн 102 иргэнийг 7.890.000 төгрөгний торгуулийн арга хэмжээ тооцон ажилласан байна.






ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМ
Анхаарал хандуулсанд
баярлалаа
WWW.BAYANTAL.GS.GOV.MN